



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
177 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7.3, 7.4, 7.8.6, 7.8.7, 7.11 дэх заалтыг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт цахимаар зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
 - 2.2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;
 - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
 - 2.4. 2020 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;
 - 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
 - 2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай;
 - 2.7. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр байхаар тогтсугай.
4. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс хоёроос доошгүй өдөр тутмын сонин, телевиз, компанийн болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, зарыг 2022 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 1 дүгээр хавсралтаар, танилцах баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төв

байранд болон цахим хэлбэр /www.telecommongolia.mn/-ээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Цэцэгмаа/-д даалгасугай.

6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-ыг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10:30 цаг байхаар тогтсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар С.Нямбаярыг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Д.Ганцэцэг, гишүүдээр Б.Хулан, С.Цог нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Ч.Цогтгэрэл, гишүүдээр Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Ч.Цогтгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЛХАГВАСҮРЭН

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	11:00-11:30
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хэлэлцүүлэх	70 минут
	1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;	
	2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;	
	3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;	
	4. 2020 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;	
	5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;	
	6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай;	
	7. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай	
70	Асуулт хариулт, санал	30 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2021 оны жилийн тайлан
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
3. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
4. ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт
5. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин,
6. ТУЗ-ийн 2021 оны ажлын тайлан
7. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийн төсөл
8. 2020 оны ногдол ашиг тараасан тухай тайлан
9. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн мэдээлэл
10. Актлах хөрөнгийн тухай танилцуулга

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерийн овог нэр

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
1.	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
2.	Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай: 1.1. Нийт хөрөнгийг ... төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг ... төгрөгөөр; 1.2. Өр төлбөрийн нийт дүнг ... төгрөгөөр; 1.3. Эзэмшигчийн өмчийг ... төгрөгөөр тус тус баталсугай. 2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.			
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг баталсугай.			

4.	ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай. 2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.			
5.	Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгөөс хасахаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг баталсугай. 2. Үндсэн хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг гүйцэтгэх захиралд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасугай.			

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг	Улсын бүртгэлийн дугаар
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал..... Гарын үсэг:.....
Регистрийн дугаар:	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн дансны

--	--	--	--	--	--	--	--	--	--

 дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерийн овог нэр

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	Ердийн гишүүд	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		
5		

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг	Улсын бүртгэлийн дугаар
мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал.....
	Гарын үсэг:

Регистрийн дугаар:	
Саналын хувьдсыг хвлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хувьдсыг хвлээн авсан этгээлийн нэр, гарын үсэг	

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна. Кумулятив аргыг хэрэглэж, сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд үйлчлүүлж буй үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг утсаар лавлаж болно.
3. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (0) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) эсхүл (0), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+) эсхүл (0), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) эсхүл (0) тэмдэгтавина.
4. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа Татгалзсан тохиолдолд өгөх санал гэсэн багананд бичнэ үү
5. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн бол санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэрэв та Саналын хуудсыг буруу бөглөсөн бол санал өгч буй этгээд нь Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө Саналын хуудсыг дахин авч бөглөж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....